

“ХОРГО ХАЙРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр

Улаанбаатар хот

“Хорго Хайрхан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн заалтууд, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам” болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2019 оны 4 сарын 25-ны өдрийн 09:40 минутаас Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, “Монгол даатгал” ХХК байр, 3 давхарт хурлынтанхимд хувьцаа эзэмшигчдийг бүртгэж эхэлсэн ба хурал 10:00 минутанд эхлэв.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөрийн танилцуулснаар:

“Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй **110’018** ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны **81,42** хувийг төлөөлсөн **2** хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч:

Саналын эрх бүхий хувьцааны 81,35 хувийн хувьцаа эзэмшигч Монгол Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Ч.Энх-Амгалан**, Саналын эрх бүхий хувьцааны 0,07 хувийн хувьцаа эзэмшигч болох Би Ди Сек ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч **Н.Өнөрбаян** нар хуралд оролцов.

Хурал даргалагч Б.Аюуш ээлжит хурлыг нээж, ээлжит хурал хуралдуулах тухай “Хорго Хайрхан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн тогтоолыг товч танилцуулав. Улмаар хурлын дэгийг танилцуулав.

1.	Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах, ирц бүртгэх	15
2.	Хурлын ирцыг мэдээлэх	3
3.	Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж хурлаар хэлэлцэх асуудлууд хурлын дэгийг танилцуулах	5

4.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах асуудал тус бүр дээр асуулт хариулт явуулах, санал шүүмжлэлийг сонсох, саналын хуудсыг хурааж авах	50
5.	Тооллогын комиссын дүн болон тогтоолыг уншиж танилцуулах	5
6.	Хурлаас гарах хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр тогтоолыг уншиж танилцуулах	5
7.	Хурлын дарга хурлыг хаах	3
8.	Бусад	5

Хурлын дарга Б.Аюуш: Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье. Өнөөдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн хүмүүсийг танилцуулъя: Намайг Б.Аюуш гэдэг өнгөрсөн жил “Хорго Хайрхан” ХК-ийн ТУЗ-ын хараат бус гишүүнээр нэр дэвшиж сонгогдсон. Энэ жил дахин нэр дэвшсэн байгаа. Дараагийн хүн бол “Хорго Хайрхан” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Монгол Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Ч.Энх-Амгалан**, “Хорго Хайрхан ХК”-ийн ТУЗ-д нэр дэвшигч Ц.Мөнхбат болон Р.Энхбаяр. Гендекс ҮЦК ХХК-ийн Э.Төгөлдөр, Д.Сайнбаяр, Би Ди Сек ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч **Н.Өнөрбаян** нар хуралд оролцож байна.

Хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ингээд бүгдээрээ хурлаар хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Бидний хэлэлцэх эхний асуудал бол “Хорго Хайрхан” ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт юм.

Хурлын дарга Б.Аюуш: “Хорго Хайрхан” ХК –ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд оруулсан.

“Хорго Хайрхан” ХК-ийн хувьд өнгөрсөн жил Монгол Даатгал ХХК-тай нэгдэх ажлын хүрээнд хэд хэдэн ажлыг хийж хэрэгжүүлсэн. Нэгтгэх ажлын явцад Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хөрөнгийн биржид албан тоотуудыг хүргүүлж, “Хорго Хайрхан” ХК-д хөрөнгийн үнэлгээ хийлгэн, хуулийн фирмийн дүгнэлт гаргах, хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх зэрэг ажлуудыг хийсэн. Дээрх ажлуудтай холбоотой зарим нэг шийдвэрүүд хүлээгдэж, нэгдэх ажил удаашралтай байсан. Тиймээс 2018 оны хувьд компани үйл ажиллагаа явуулаагүй. Санхүүгийн тайлангын хувьд бид тайлангаа Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй “Гроут Финанс Аудит” ХХК-иар баталгаажуулсан. Аудитын компанийн зүгээс 2014 онд “Хорго Хайрхан” ХК нь

хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэхдээ, дахин үнэлгээний зөрүү дүнг өөрийн хөрөнгөрүү бүртгэсэн алдаатай бичилтийг илрүүлэн, залруулга хийсэн байгаа. Өнгөрсөн онд ерөнхийдөө нэгтэх үйл ажиллагаатай холбоотой ажлуудаа түлхүү хэрэгжүүлсэн учраас ТУЗ-ийн хувьд тависан зорилгодоо хүрч ажилласан гэж үзэж байна.

Хурлын дарга Б.Аюуш: Дараагийн хэлэлцэх асуудал нь Ногдол ашиг хувиарлахгүй байх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах юм. 2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны зогсонги байдлаас шалтгаалан 2019 онд ногдол ашиг тараах боломжгүй гэж ТУЗ шийдвэрлэсэн.

Хурлын дарга Б.Аюуш: Дараагийн асуудал бол Монгол Даатгал ХХК-г Хорго Хайрхан ХК-нд нэгтгэх үйл ажиллагаатай холбоотой журам, гэрээний өөрчлөлттэй холбоотой. Өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан боловч даатгалын компаниудын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөх шаардлагыг Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан. Энэ шаардлагын дагуу Монгол Даатгал ХХК-иас дээрх ажилтай холбогдуулан тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Нэгтгэх гэрээ, журамд нэмэлт өөрчлөлт оруулсан төслийг та бүхэнд тараасан байгаа. Энэхүү төслүүд дээр хоёр өөрчлөлт гарсан.

1-рт нь Хоёр компанийн 2018 оны Санхүүгийн тайлангийн санхүүгийн үзүүлэлтүүд өөрчлөгдсөн тул эдгээр өөрчлөлтүүдийг дахин шинэчилж гэрээ, журамд оруулсан.

2-рт Өнгөрсөн жилийн хувьд хоёр компанийн санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгөд үндэслэн хувьцааг хөрвүүлэх тооцоог хийхдээ Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын заалтыг дагаж мөрдсөн боловч Хөрөнгийн бирж, Хорго Хайрхан ХК хоёрын дунд ойлголтын зөрүү үүссэн. Дахин үнэлгээний зөрүүг оруулахгүй зөвхөн өөрийн хөрөнгө дээр үндэслэн хувьцааг хөрвүүлэх тооцоо хийх ёстой гэсэн асуудал дээр удаан хугацаанд хэлэлцсэн. Ингээд бид Санхүүгийн тайлагналын олон улсын стандарттай холбоотой асуудлаар аудитын компаниудтай уулзаж “Хорго Хайрхан” ХК-ийн бүртгэл олон улсын стандартад нийцсэн байна гэсэн дүгнэлт авсан. Гэхдээ бид энэ жил дээрх асуудлыг үүсгэхгүй байх үүднээс хувьцааны хөрвүүлэлтийг хийхдээ зөвхөн өөрийн хөрөнгө болон хуримтлагдсан ашгийг оруулж тооцсон байгаа шүү. Өөрөөр хэлбэл хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг оруулалгүй, тооцож, нэгдсэн санхүүгийн тайланд Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү гэсэн нэрээр нь тусгахаар өөрчлөлт хийсэн байгаа.

Мөн хувьцаагаа эргүүлэн худалдан авах журмыг дахин баталгаажуулсан.

Хурлын дарга Б.Аюуш: Сүүлийн асуудал бол бидний өнгөрсөн жил баталсан зарим тогтоолууд дахин баталгаажуулж байгаа асуудал юм. Та бүхэнд тараасан байгаа тул уншиж танилцсан байх гэж найдаж байна. За асуух зүйл байна уу?

Асуух зүйл байхгүй гэв.

Хувьцаа эзэмшигч нарт санал өгөх хуудсанд санал өгөх журмыг тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр танилцуулахаар болов.

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр: Хувьцаа эзэмшигчид санал өгөх журмыг тайлбарлав.

Тооллогын комисс саналын хайрцаг хоосон, битүүмжилсэн болохыг хуралд оролцогчдод үзүүлэв. Улмаар хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгцгөөв. Дараа нь тооллогын комисс санал тоолох ажилдаа орж, хуралд тооллогын дүнг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр: Санал хураалтын үр дүнд үндэслэн Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хэлэлцсэн асуудлын дагуу саналын хуудсаар санал авч дараах үр дүнд хүрлээ.

1. 2018 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлахыг зөвшөөрсөн саналын эрхтэй хувьцааны тоо 110'018 ширхэг буюу нийт саналын эрхтэй хувьцааны 81,42 %, хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцааны 100% татгалзсан санал байхгүй, түдгэлзсэн санал байхгүй тул баталсанд тооцов.

Хурлын дарга Б.Аюуш: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэн хурлаас гарах шийдвэрүүдийг танилцуулав.

1. Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Хорго Хайрхан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж тооцсугай.
-

-
2. Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Хорго Хайрхан” ХК-ийн 2018 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
 3. Хорго хайрхан ХК-д Монгол даатгал ХХК-ийг нэгтгэх гэрээ болон Нэгтгэх журамд нэмэлт өөрчлөлт оруулан баталсугай.
 4. Өнгөрсөн оры хувьцаа эзэмшигчдийн хурлын зарим шийдвэрийг дахин баталгаажуулсугай.

Хурлын дарга Б.Аюуш: Хурал хаасныг мэдэгдэв.

Хурал 2019 оны 04 дүгээр 25 сарын -ний өдрийн 12 цаг 05 минутад өндөрлөв.



ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д.САЙНБАЯР

ХУРЛЫН ДАРГА:

Б.АЮУШ